

2. Шуухмйн тогтоолыг гуйцэтгуулэх зорилгоор шилжуулэн өгөх тухай шаардлагад шуухийн хучин төгөлдөр болсон тогтоолын баталгаа бүхий хуулбар, гэмт хэрэгт ял ноогдуулсаы хуулийн зуйл ангийн бүрэн тодорхойлолтыг бичнэ. Хэрэв шуугдэгч ялын зарим хэсгийг эдэлсэн бол тэр тухай нэг адил мздэгдэнэ.

3. Хэрэв цагдан хорих тухай тогтоол болон туслан шийдвэрлэсэн тогтоолд тодорхой ороогуй бол шилжуулэн өгөх этгээдийн гэрэл зураг, биеийн гадаад байдлын тодорхойлолт, тууний товч туухт байдал, аль удсын харьяат буюу оршин суудаг газрын тухай шилжуулэн өгөх тухай шаардлагад нэг адил бололцоогоор хавсаргана.

Наядугаар зуйл

Шилжуулэн өгөх тухай шаардлагын
талаар нэмэлт материал шаардах

Хэрэв шилжуулэн өгөх тухай шаардлагад оруулбал зохих материалыг гуйцэд хийгээгүй бол уг шаардлагыг хулээн авч байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээд кэмэлт материалыг хугацаа зааж шаардана.

Нэмэлт материал ируулэх хугацааг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээдийн хусэлтээр сунгажболно.

Шилжуулэн өгөх этгээдийг баривчлах

Наян нэгдүгээр зуйл

Шилжуулэн өгөх шаардлагыг Хэлэлцэн Тохирогч нөгөө Этгээд хулээн авсан даруй уг этгээдийг эрж олох, зарим уед туунийг баривчлах арга хэмжээ авна.

Наян хоёрдугаар зуйл

I. Хэрэв шилжуулэн өгөх тухай хусэлтээ явуулж байгаа Хэлэлцэн Тохирогч Этгээдийн эрх бүхий байгууллага уг